



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

___ оны __ сарын __ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх
үйл ажиллагааны журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Татварын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/-т даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2009 оны 531 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх заавар”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

Ч.ХҮРЭЛБААТАР

ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ ЭДЛҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Татварын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлд заасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх харилцааг зохицуулахад энэ журмыг баримтална.

1.2.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэхэд татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан “Хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам”-ыг баримтална.

1.3.Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5-д заасны дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах татвар төлөгч татварын тайлан тушаах үүргээс чөлөөлөгдөхгүй бөгөөд уг татварын тайлан нь түүнийг тухайн төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах үндсэн баримт болно.

1.4.Хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх татвар төлөгч нь тухайн төрлийн татварын тайланг хавсралт мэдээ, нотлох баримтын хамт батлагдсан маягтын дагуу татварын албанд цахим, эсхүл цаасан хэлбэрээр ирүүлнэ.

1.5.Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлэхдээ Татварын ерөнхий хуулийн 15 дугаар зүйлд заасан хугацааг баримтална.

1.6.Татварын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд заасан татварын хялбаршуулсан горим ашиглах татвар төлөгчид энэ журам хамаарахгүй.

1.7.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.9-д заасны дагуу тусгай зөвшөөрөл тус бүрд хамаарах татварын тайланг гаргаж байгаа хуулийн этгээд нь тайлан тус бүрд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлнэ.

1.8.Албан татвар, төлбөрөөс чөлөөлөгдөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч нь энэ журмын хавсралтаар баталсан “Албан татвар, төлбөрөөс чөлөөлөгдөх хүсэлтийн маягт”-ыг нотлох баримтын хамт уг хөрөнгийг эзэмшиж эхэлснээс хойш ажлын 5 өдрийн дотор цахим, эсхүл цаасан хэлбэрээр харьяалах татварын албанд илгээж, уг хүсэлтийг татварын алба хянан, баталгаажуулна.

Хоёр.Татвараас чөлөөлөх

2.1.Татвар төлөгч нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйл болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан бараа, ажил үйлчилгээний орлогыг албан татвараас чөлөөлөхдөө нийт борлуулалтын орлогын дүнгээс чөлөөлөгдөх орлогыг хасаж тооцно.

2.2.Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан төлбөрийг чөлөөлөхдөө нийт ногдуулсан төлбөрийн дүнгээс чөлөөлөгдөх төлбөрийг хасаж тооцох бөгөөд мөн хуулийн 8.2, 8.3, 8.4-т заасан автотээврийн хэрэгсэл эзэмшигчийн хувьд энэ журмын 1.8-д заасан хүсэлтийн дагуу татварын алба хөрөнгө эзэмших эрхийн гэрчилгээнд үндэслэн төлбөрөөс чөлөөлнө.

2.3.Татварын алба дараах хөрөнгийг албан татвараас чөлөөлөхдөө энэ журмын 1.8-д заасан хүсэлт, хөрөнгө өмчлөх, эзэмших эрхийн гэрчилгээнд үндэслэнэ.

2.3.1.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.5-д заасан үл хөдлөх эд хөрөнгө;

2.3.2.Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд заасан үр тарианы комбайн, гинжит трактор;

2.3.3. Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан галт зэвсэг.

2.4. Борлуулалтын орлогын хэмжээ 50.0 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасны дагуу албан татвараас чөлөөлөгдөх бараа, ажил, үйлчилгээг дагнан эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээд нь ажлын 10 өдөрт багтаан дараах материалыг бүрдүүлж харьяалах татварын албанд ирүүлснээр нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх үүргээс чөлөөлөгдөнө:

- 2.4.1. албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх үүргээс чөлөөлөгдөх хүсэлт;
- 2.4.2. чөлөөлөгдөх бараа, ажил, үйлчилгээ эрхэлдэг болохыг нотлох баримт;
- 2.4.3. аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл;
- 2.4.4. бусад /цахим төлбөрийн баримт, гэрээ, анхан шатны баримт гэх мэт/.

2.5. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.3-т заасан үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгч нь татвар төлөгчөөр бүртгүүлэх, тайлагнах үүргээс чөлөөлөгдөнө.

2.6. Ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлөхдөө тайландаа хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүнг тусган төлбөл зохих төлбөрөөс хасаж тооцно.

2.7. Энэ журмын 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6-д зааснаас бусад албан татвар, төлбөр, хураамжийн хувьд чөлөөлөлтийг эрх бүхий төрийн захиргааны байгууллага эдлүүлж, татварын албанд батлагдсан тайлангийн маягт, хавсралт мэдээний дагуу тайлагнана.

Гурав.Татварын хөнгөлөлт эдлүүлэх

3.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасны дагуу хөнгөлөлтийг өөрөө сонгож эдлэх бөгөөд хөнгөлөлтийг хэсэгчлэн, дараагийн татварын жилд шилжүүлэн эдлүүлэхгүй.

3.2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2.7-д заасан 1 хувиар албан татвар төлөх, 22 дугаар зүйлийн 22.1-д заасан 90 хувийн хөнгөлөлт эдлэх албан татвар төлөгч нь энэ журмын 3.4-т заасан хөнгөлөлтийг эдлэхгүй.

3.3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан албан татварын хөнгөлөлтийг албан татвар төлөгчийн жилийн эцсийн татварын тайлангаар тодорхойлон, мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасан хугацаанд төлсөн албан татварыг буцаан олгох замаар эдлүүлнэ.

3.4. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д заасан хөнгөлөлтийг тайлант хугацаанд ногдуулан төлсөн татварын хэмжээнд үндэслэн эдлүүлнэ.

3.5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.1, 22.5.2, 22.5.4, 22.5.6-д заасан хөнгөлөлтийг эдлүүлэхдээ дараах шалгуурыг баримтална:

3.5.1. хуулийн 22.5.1-д заасан Улаанбаатар хотоос аймаг, сум хүртэлх зайг зам тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон улсын болон орон нутгийн чанартай авто замуудын эхлэл, төгсгөлийн цэгийн тодорхойлолт, ажлын байр бий болгож байгаа гэдгийг хоёр ба түүнээс дээш үндсэн ажилтныг 6 сараас дээш хугацаагаар ажлын байраар хангасан байх;

3.5.2. хуулийн 22.5.2, 22.5.6-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоог цалин, хөдөлмөрийн хөлснөөс суутгасан албан татварын тайлан, нийгмийн даатгалын тайланг үндэслэн тодорхойлох бөгөөд гэрээт ажилтныг нийт ажиллагчдын тоонд оруулахгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоосон бичиг баримтыг үндэслэн тогтоох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвараа 50 болон түүнээс дээш хувиар алдсан иргэн тухайн аж ахуйн нэгжид 6 сараас дээш хугацаагаар ажилласан байх;

3.5.3.Хуулийн 22.5.4-т заасан бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг Засгийн газраас баталсан жагсаалтыг баримтлан инновацийн бүтээгдэхүүний талаар мэргэжлийн шинжээчийн гаргасан дүгнэлт, эрх бүхий байгууллагаас гаргасан мэдээлэл, гарааны компанийн гэрчилгээнд үндэслэх.

3.6.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасан газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хөнгөлөлтийг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эдлүүлж, татварын албанд тайлагнана.

Дөрөв.Хөнгөлөлт, чөлөөлөлтийг баталгаажуулах, тооцоо хийх

4.1.Татвар төлөгч нь татварын тайлан, хавсралт мэдээ, нотлох баримт, илүү төлсөн татварыг буцаан авах хүсэлтийг татварын албанд ирүүлнэ.

4.2.Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэхээр холбогдох хуульд заасан үйл ажиллагаа, орлого, хөрөнгө, татварыг хуульд тогтоомжид заасан нөхцөл, шалгуурт нийцүүлэн татварын тайланд үнэн зөв тусгасан эсэхийг энэ журмын 4.7-д заасан нотлох баримттай тулган “Татварын тайлан үйлдэх, хүлээн авах, боловсруулах, тайланд залруулга хийх журам”-д заасны дагуу татварын алба хянан, баталгаажуулж татвар төлөгчид мэдэгдэнэ.

4.3.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хүлээн авсан татварын тайланд үндэслэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх татвар төлөгчийн жагсаалтыг тухайн татварын албаны даргын тушаалаар баталгаажуулж тайлан хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг хариуцсан нэгжид ирүүлнэ.

4.4.Энэ журмын 4.3-т заасныг үндэслэн татварын хөнгөлөлт эдлүүлэх аж ахуйн нэгжийн жагсаалтыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын татварын орлогын чиг үүрэг хариуцсан нэгжид дараах хугацаанд хүргүүлнэ:

4.4.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан хөнгөлөлтийг буцаан олгох аж ахуйн нэгжийн жагсаалтыг тайлан хүргүүлэх хугацаанаас хойш ажлын 15 өдрийн дотор;

4.4.2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д заасан татварын хөнгөлөлт эдлэх аж ахуйн нэгжийн жагсаалтыг дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор.

4.5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлтийг буцаан олгохдоо Сангийн сайдын тушаалаар баталсан “Илүү төлсөн албан татварыг буцаан олгох, хяналт тавих, нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулах журам”-ыг баримтална.

4.6.Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхтэй холбоотой татвар төлөгчөөс ирүүлэх нотлох баримтын жагсаалтыг тухайн татварын тайлангийн маягт нөхөх зааварт тусгана.

4.7.Татварын хөнгөлөлтийн тайлан тушаасан аж ахуйн нэгж тайлангийн ногдлыг бууруулах, тайлангийн залруулга хийхээр хүсэлт ирүүлсэн тохиолдолд энэ журмын 4.6-д заасан нотлох баримтыг хавсаргана.

4.8.Энэ журмын 4.7-д заасан тайлан залруулах хүсэлт ирүүлсэн, хүсэлтийг шийдвэрлэн тайлангийн ногдолд өөрчлөлт оруулсан тохиолдолд буцаан олголт хариуцсан нэгжид тухай бүр мэдэгдэнэ.



ТӨСӨЛ
/2019.08.29-ний өдөр/

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх
үйл ажиллагааны журмын хавсралт

Монголын Татварын Алба

Маягт

ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

Үзүүлэлт

Харьяалах татварын алба
Татвар төлөгчийн нэр
Татвар төлөгчийн дугаар
Үйл ажиллагааны чиглэл
Хаяг
Цахим шуудангийн хаяг
Харилцах утасны дугаар
Хөрөнгийн төрөл
Хөрөнгийн гэрчилгээний хуулбар

Мэдээлэл

[[[_____

[[[[[[[[[[[[[[[[[[[[

[[[[[[[[[[[[

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-7.1.5, Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8, Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан /хамаарах зүйл, заалтын доогуур зурах/ хөрөнгийг өмчлөгч, эзэмшигч тул албан татвараас чөлөөлөгдөх хүсэлтийг хүргүүлж байна.

Хүсэлт гаргасан:

..... //
Гарын үсэг, тэмдэг нэр



/2019.08.29-ний өдөр/

Маягт

Үзүүлэлт

Хөрөнгийн гэрчилгээний хуулбар

Мэдээлэл

||| _____

||| ||| ||| ||| ||| ||| ||| |||

||| ||| ||| ||| ||| ||| |||

Хүсэлт гаргасан:

..... /

Гарын үсэг, тэмдэг нэр

